



**ХЭНТИЙ АЙМГИЙН БАЯН-АДАРГА СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2026 оны 02 сарын 02 өдөр

Дугаар Б/04

Баян-Адарга сум

**Б.Гүрсүрэнг албан тушаалд
томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.4, 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1 дэх заалт, Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсэг, Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоол, албан хаагчийн гаргасан хүсэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Батболдын Гүрсүрэнг 2026 оны 02 дугаар сарын 02-ны өдрөөс сумын Засаг даргын Тамгын газрын Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтнээр томилсугай.

2. Б.Гүрсүрэнгийн албан тушаалын үндсэн цалинг ТЗ ангилалын 9 дүгээр зэрэглэл буюу 1 283 000 (нэг сая хоёр зуун наян гурван мянга) төгрөгөөр тогтоож, хуульд заасан бусад нэмэгдэл хөлсийг сар бүр тооцож, олгож ажиллахыг Нягтлан бодогч (Б.Агиймаа)-д зөвшөөрсүгэй.

3. Албан тушаалын тодорхойлолтоор хүлээсэн ажил үүрэг, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг цаг тухай бүр ханган биелүүлж, ажлын бүтээмж, ёс зүйг эрхэмлэн сахилга, хариуцлагатай ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн (Б.Гүрсүрэн)-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.БАТ-ЭРДЭНЭ